



ХОВСГОЛ АЙМГИЙН  
ТОМЮРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАХИРАМЖ

2024 оны 05 сарын 30

Дугаар А/49

Томюрбулаг сум

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс  
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.6, Аймгийн засаг даргын 2024 оны 05 сарын 27-ний өдрийн А/272 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал амьтны гоц халдварт өвчин зөөвөрлөгдөн дамжин тархах болзошгүй эрсдлээс сэргийлэх зорилгоор сумын хэмжээний үхэр сүргийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт даалгасугай.

2. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа хороог бэлдэж, бэлтгэл ажлыг ханган ажиллахыг багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган тайлан мэдээ, санхүүгийн баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Тархвар зүйч /Э.Мөнгөзагас/-т даалгасугай.

4. Ажлын хэсгийг шаардагдах шатахуунаар ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Х.Даваачулуун/-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Нямханд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.МӨНХ-ЭРДЭНЭ